

**УЛС ТӨРИЙН НАМЫН ГИШҮҮНЧЛЭЛ, ТӨЛӨВШИЛ, НУТГИЙН ӨӨРӨӨ УДИРДАХ  
БАЙГУУЛЛАГЫН СОНГУУЛЬ, ПАРЛАМЕНТ БОЛОН ОРОН НУТГИЙН СОНГУУЛИЙГ  
ЗЭРЭГ ЯВУУЛАХ НЬ** /Лавлагаа, мэдээлэл/

*Ч. Базар (Ph.D), П. Амаржаргал, Б. Хатантуул,  
Б. Цолмонбаяр*

### 1. Улс төрийн намын гишүүнчлэлийн талаар

“Орчин үеийн ардчилал нь намуудын ардчилал юм.”[1] Намын тухай онол, үзэл санаа хэлбэршин төлөвших хүртлээ хүнд хэцүү сорилтыг туулсан байна. Эхэн үедээ намыг нийгэмд ашиггүй, зөрчил хуйвалдааны эх сурвалж гэж үзэж хяхаж хавчсаар иржээ. Яваандаа нийгэмд намын гүйцэтгэх үүрэг өсөх болсонтой холбоотойгоор түүнийг эерэг талаас нь үнэлэх хандлага мэдэгдэхүйц нэмэгдсэн юм. Намын түүхэнд эзлэх байр суурийг зөв бодитой гаргаж тавих үйл хэрэгт сэтгэгч Н.Макиавелли, Ш.Л.Монтескье нар чухал үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Францын улс төрийн философич Реймон Арон “... намуудын зорилго бол засаглалыг хэрэгжүүлэх биш, харин засаглалыг хэрэгжүүлэхэд оролцох явдал юм” гэжээ. Эндээс үзвэл засаглалыг хэрэгжүүлэхэд намуудын хууль ёсны зохистой оролцоо нь ардчилсан нийгэм дэх хэвийн бөгөөд эрүүл үзэгдэл мөн ажээ.

Монголын ардчиллын төлөвшил нь намуудын төлөвшлөөс ихээхэн хамааралтай. Манай улсын хувьд улс төрийн намын эрх зүйн байдлыг “Монгол Улсын Үндсэн хууль”, “Улс төрийн намын тухай хууль”, сонгуулийн тухай хуулиудаар тодорхой зохицуулсан. Олон намын систем төлөвшөөд 20 жил болох хугацаанд нийт 26 улс төрийн нам байгуулагдсанаас 9 нь татан буугдаж өдгөө Улсын Дээд шүүхэд бүртгэлтэй 18 нам байна.[2] Гэвч эдгээрээс орчин үеийн улс төрийн намын шалгуурыг хангах хэмжээнд төлөвшсөн нь цөөхөн юм. Харин намын хэв шинжийн хувьд МАН, АН -уудыг “кадрын нам”, “олон түмний нам”, “өргөн хүрээний нам”-ын завсрын хэв шинжтэй гэж үзэж болох бол зарим жижиг намууд нь кадрын, зарим нь зөвхөн эрх зүйн шалгуураар л нам гэж тооцож болохоор төвшинд байна.[3]

| № |  | МАН                  | АН                   | Иргэний зориг, |
|---|--|----------------------|----------------------|----------------|
| 1 | Бүтцийн хэлбэр                               | Шууд бүтэц           | Холимог              | Шууд бүтэц     |
| 2 | Бусад элементүүд ба нэгдсэн бүтцийн хамаарал | Босоо холбоос        | Холимог              | Босоо холбоос  |
| 3 | Намын гишүүнчлэл                             | Хатуу                | Хатуу                | Хатуу          |
| 4 | Нийгмийн төлөөлөл                            | Тогтсон дэмжигчидтэй | Тогтсон дэмжигчидтэй | Бага           |
| 5 | Удирдлага                                    | Төвлөрөл их          | Төвлөрөл их          | Лидер дагасан  |
| 6 | УИХ дахь давамгайлал                         | Их                   | Их                   | -              |

|   |                               |   |   |   |
|---|-------------------------------|---|---|---|
| 7 | Намын санхүүжилт              | -Гишүүний татвар хандив<br>-Төрийн санхүүжилт | Гишүүний татвар хандив<br>-Төрийн санхүүжилт          | Гишүүний татвар хандив<br>-Төрийн санхүүжилт        |
| 8 | Сонгуулийн компанийн хэв маяг | Уламжлал агуулсан модерн                      | Модерн агуулсан уламжлалт                             | Модерн агуулсан уламжлалт                           |
| 9 | Төлөвшиж буй хэв маяг         | Олон түмний нам                               | Өргөн хүрээний зарим шинжийг агуулсан олон түмний нам | Кадрын намын зарим шинжийг агуулсан олон түмний нам |

Монгол улсын Дээд шүүхэд улсын бүртгэлтэй улс төрийн намуудын мэдээлэл [4]

| дд | Намын нэр  | Анх байгуулагдсан он | Гишүүдийн тоо |
|----|--|----------------------|---------------|
| 1  | Монгол Ардын нам /МАН                                | 1921.03.01           | 161300        |
| 2  | Ардчилсан нам  | 2000.12.25           | 150000        |
| 3  | Монголын Ногоон нам /МНН/                            | 1990.05.13           | 2100          |
| 4  | Иргэний Зориг нам /ИЗН/                              | 2000.03.09           | 35000         |
| 5  | Монголын Уламжлалын Нэгдсэн нам /МУНН/               | 1993.12.05           | 1503          |
| 6  | Монголын Либерал Ардчилсан Нам /МЛАН/                | 1998.05.21           | 863           |
| 7  | Эх Орон нам  | 1998.12.22           | 160.000       |
| 8  | Монголын Либерал Нам /МЛН/                           | 1999.12.17           | 1300          |
| 9  | Бүгд Найрамдах Нам /БНН/                             | 2004.03.15           | 50000         |
| 10 | Монголын Эмэгтэйчүүдийн Үндэсний Нэгдсэн Нам /МЭҮНН/ | 2004.4.12            | 1069          |
| 11 | Монголын Социал Демократ Нам                         | 2004.12.19           | 3000          |
| 12 | Ард Түмний Нам /АТН/                                 | 2005.12.11           | 11859         |
| 13 | Үндэсний Шинэ Нам                                    | 2006.05.19           | 2400          |
| 14 | Эрх Чөлөөг Хэрэгжүүлэгч Нам                          | 2006.10.09           | 1600          |
| 15 | Иргэний Хөдөлгөөн Нам /ИХ/                           | 2007.08.17           | 815           |
| 16 | Хөгжлийн Хөтөлбөр Нам                                | 2007.10.28           | 933           |
| 17 | Монголын Ардчилсан Хөдөлгөөний Нам                   | 2008.02.01           | 850           |
| 18 | Монгол Ардын Хувьсгалт Нам                           | 2011.06.24           |               |

Зарим улс орны намуудын гишүүнчлэлийн тухайд

Дэлхийн улс орнууд улс төрийн намын гишүүнчлэлээрээ хатуу гишүүнчлэлтэй, сул гишүүнчлэлтэй, гишүүнчлэлгүй гэж хуваагддаг. Англи, Америкийн улс төрийн уламжлалтай улс орнуудын хувьд намыг Парламент дахь намын бүлгийн түвшинд их төлөв тайлбарлахаас гадна хатуу тогтсон бүтэц, зохион байгуулалтгүй, тодорхой гишүүнчлэлгүй, сонгуулийн үед идэвхждэг, мэргэжлийн цөөн хүмүүсийн бүлэглэл маягаар ойлгодог аж. Харин их газрын Европын болон аж үйдвэржихийн өмнөх хийгээд аж үйлдвэржиж буй орны улс төрийн системтэй улс орнуудын судлаачид намыг хатуу тогтсон үзэл санаа, зохион байгуулалттай, байнгын гишүүнчлэлтэй, тогтмол идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг, хяналтын нарийн механизмтай олон түмний бүлэглэл хэлбэрээр тайлбарладаг байна.

Эндээс үзвэл өнөө хэр улс төрийн намын талаар цэгцтэй нэгдмэл ойлголт бүрэлдэж хараахан чадаагүй нь харагдаж байна. Хэдий тийм боловч улс төрийн намыг авч үзэхдээ дараахи гол ерөнхий шинжийг зайлшгүй харгалзан үзэх хэрэгтэй байдаг. Нэгд, санаа бодол нэгдмэл буюу ойролцоо хүмүүсийн бүлэглэл, хоёрт, үйл ажиллагааны тодорхой зорилго, чиглэл, үзэл санаа, хөтөлбөртэй байх, гуравт, ямар нэг хэмжээгээр зохион байгуулалтын тодорхой бүтэцтэй байх, дөрөвт, засгийн эрхийг авах эрмэлзлэл, түүнийг хэрэгжүүлэх нөөц чадвартай байх. Энэхүү ерөнхий шаардлага шалгуурыг хангаж чадаж буй бүлэглэлийг нам гэж үзэж болох юм. [5]

Улс төрийн намыг заавал бүртгэж байх эрх зүйн акт бүхий тогтолцоотой орнууд байх бөгөөд Испани, Итали, Францад намыг Дотоод хэргийн яам нь, Бельги, Нидерландад (Голланд) Хууль зүйн яам нь, АНУ-ын Миссури мужид мужийн Төрийн нарийн бичгийн газар нь, Португали, Бразильд Дээд шүүх нь бүртгэдэг байна. Энэтхэг, Мексик, Швейцарьт сонгууль явуулахын тулд байгуулагдсан байгууллагууд бүртгэдэг байна.

Нам байгуулж, бүртгүүлэхэд аль ч улс оронд нэг голлодог зүйл нь тухайн намын гишүүд болон дэмжигчдийн тоо байдаг. Швейцарьт нам бүртгүүлэхэд сонгогчдын 1.5 мянгаас доошгүй гарын үсэг цуглуулах шаардлагатай байдаг бол Португалид 5 мянган сонгогчийг төлөөлсөн байх үүрэгтэй. Эдгээр нь тухайн улсын сонгогчдын буюу сонгуульд оролцож санал өгөх насны нийт хүмүүсийн тоотой харьцуулсан хувь юм.

АНУ-ын 20-иод муж улсын хууль тогтоох байгууллага намуудаас сонгогчдын ерөнхий тооны хувиар илэрхийлсэн тодорхой тооны гарын үсгийг шаарддаг байна. Жишээ нь, Өмнөд Дакотад энэ тоо 10 хувь байдаг бол Миннесотад 5 хувь байдаг. Ингэхдээ муж улсын түвшинд тухайн намын гишүүн ямар нэг албан тушаалтан сүүлийн сонгуульд нэр дэвшиж ялсан, эсвэл бүх нэр дэвшигчдийн төлөө санал өгсөн хүмүүсийн хувиас хамааран бүртгэдэг байна. Анхаарах зүйл, дээрх зарчим нь сонгогчдын төлөөлөл болохоос биш манайх шиг хатуу гишүүнчлэлтэй улсынх шиг намын гишүүдийн тоог илэрхийлж байгаа асуудал биш юм. Барууны орнуудад намын гишүүнчлэл гэж бараг байдаггүй, зөвхөн дэмжигчид байдагтай энэ нь хамааралтай.

Намын хатуу гишүүнчлэлтэй орнуудын хувьд, тухайлбал:

- БНУУ-д нам бүртгүүлэхэд гишүүн үүсгэн байгуулагчдын тоо 1000 байх ёстой байдаг.
- Мексикт энэ тоо 65 мянгаар хэмжигддэг.
- Канад болон Мексик улсын хувьд сүүлийн сонгуульд оролцсон сонгуулийн насны иргэдийн Канадад 5,1 хувь [6]
- Мексикт 31,7 хувь [7] нь аль нэг намын гишүүнчлэлтэй байсан байна.

Улс төрийн намгүй орнуудын жагсаалт:

- Бахрейн
- Бутан
- Кристмасын арлууд
- Микронези
- Кувейт
- Ливи
- Мальдив
- Оман
- Палау
- Катар
- Саудын Араб
- Свазиланд
- Тонга
- Тувалу
- Арабын Нэгдсэн Эмират
- Ватикан

Улс төрийн нам хатуу гишүүнчлэлгүй тохиолдолд сонгуульд оролцоод санал авсан дэмжигчдийнхээ тоогоор “Манай нам, нийт ард түмний төдөн хувийн дэмжлэгийг авлаа” гэсэн үр дүнгээр тухайн орон эрх барих хүчнээ тодорхойлж, засаглалаа тогтоож болно. Олон орон ийм загвараар явж байна. Энэ нь тухайн орныхоо тусгаар тогтнол, эв нэгдлийн баталгааг нэмэгдүүлдэг сайн талтай ч гэж зарим судлаачид үздэг ажээ.

Намуудын төлөвшлийн тухайд

“Орчин үеийн ардчилал нь намуудын ардчилал юм.” гэсэн үзэл онолын хүрээнд Монголын намууд сонгуулийн хэв маягийн авсаархан бүтэцтэй, хатуу гишүүнчлэлгүй намын хэлбэрт аажмаар шилжих нь зүйтэй бөгөөд үүний тулд:

- Намууд юуны өмнө зорилго, бодлогын сонголтоо тодорхой болгох
- Намууд парламентын хүрээнд орж ирж, төлөвших улс төр, эрх зүйн таатай нөхцөлийг бүрдүүлэх,
- Парламент дахь намын бүлэгт хууль санаачлах эрх олгох,
- Намуудын дотоод ардчиллыг гүнзгийрүүлэх,
- Намын дотоод бүтэц, зохион байгуулалтын хүрээнд шинэчлэлт хийх,
- Намын санхүүжилтийн нээлттэй ил тод хэлбэрийг бий болгох, намд өгч буй элдэв хандивыг улсын бүртгэлтэй хандивын маягтаар тооцож байх
- Намуудын хүний нөөцийн боломжийг сайжруулан тэднийг чадавхжуулах
- Парламент дахь цөөнхийн оролцоо, үйл ажиллагааны эрх зүйн хангалттай орчин, механизмыг зоригтой бүрдүүлэх нь зэрэгт анхаарах чухал байна гэж судлаачид тэмдэглэжээ. [8]

### Эх сурвалж:

1. Жозеф А.Шумпетер “Капитализм, социализм, ба ардчилал”, Р.Даль “Ардчилал ба түүний шүүмжлэл”
2. Улсын дээд шүүх <http://www.supremecourt.mn/>
- 3.Н.Пүрэвгарьд. “Монголын улс төрийн намуудын төлөвшлийн зарим асуудал”, 2011.04.20

4. Улсын дээд шүүх <http://www.supremecourt.mn/>
5. Улс төр судлаач Д.Болд-Эрдэнэ. "Монголд нам устаж олигарх ноёрхлоо". "Өнөөдөр" сонин. 2007.07.24.
6. <http://www42.statcan.gc.ca>
7. <http://pdba.georgetown.edu/Parties/Mexico/desc.html>, <http://buscador.inegi.org.mx>
8. Д.Болд-Эрдэнэ. "Монголын улс төрийн нам, намын системийн төлөвшил, УБ., 2008

## 2. Хэт улс төржилт ямар, ямар хүчин зүйлүүдээс шалтгаалж буй талаар

Хэт улс төржилтийн талаархи энэхүү мэдээллийг зарим судлаач, мэргэжилтнүүд болон олон нийтийн санаа бодол, хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэл дээр үндэслэн тоймлов.

### Улс төржилт гэж юу вэ?

Улс төр судлалын хувьд улс төржилт (politicization, политизация) хэмээх ойлголт байдаг. Нийгэмд улс төрийн үүрэг нөлөө нэмэгдэх, олон түмний улс төрийн идэвхи өсөх, нийгмийн амьдралын ямар нэг асуудал улс төрийн хүрээний анхаарлын төвд тавигдах явдлыг улс төржилт хэмээн ойлгож болно.

### Хэтийдсэн улс төржилт

Нэр томъёоны тухайд хэт улс төржилт бус хэтийдсэн гэвэл илүү оновчтой байж болно.

### Хэрэгтэй улс төржилт

Улс төр судлалын хувьд улс төржилт (politicization, политизация) хэмээх ойлголт үнэхээр бий бөгөөд нийгэмд улс төрийн үүрэг нөлөө нэмэгдэх, олон түмний улс төрийн идэвхи өсөх, нийгмийн амьдралын ямар нэг асуудал улс төрийн хүрээний анхаарлын төвд тавигдах явдлыг улс төржилт хэмээн ойлгож болно.

1990-ээд оны ардчилсан хувьсгал нь тухайн үеийн нийгэм-эдийн засгийн хямрал, олон улсын харилцаанаас гадуурхагдсан байдал, хүний жам ёсны эрх, эрх чөлөөг хязгаарласан байдал, улс төрийн зохисгүй удирдлага зэрэг асуудлаар өргөн хэлэлцүүлэг өрнөж, монголын нийгмийн хөгжлийн цаашдын хандлагыг хэрхэн тодорхойлох талаархи үндэсний дэвшилт сэхээтнүүдийн үзэл санааны өрсөлдөөн, товчхондоо маш том улс төржилтийн үр дүн болон гарч ирсэн билээ. Нийгмийн тодорхой үе, нөхцөл байдалд нийгмийг бүхэлд нь хамарсан улс төржилт явагдах зайлшгүй шаардлага үүсдэг. Тухайлбал, нийгмийн хувьсгал, системийн шинжтэй өөрчлөлт хийх үүднээс бүх нийтийн санал хураалт явуулах, сонгуулийн үед улс төржихөөс өөр аргагүй юм.

Нийгмийн тулгамдсан асуудал улс төрийн амьдралын чухал сэдэв болох нь тухайн асуудлыг эергээр шийдвэрлэх, улс орны хөгжлийг урагшлуулахад том хүчин зүйл болдог. Тухайлбал, хотын утаа, хүн амын орон сууцны дутагдал, хүн худалдаалах хэрэг, хар тамхины хэрэглээ өсөх, гэр бүлийн хүчирхийлэл, боловсролын чанар муудах, дээд боловсрол эзэмшигчдийн жендерийн зохисгүй харьцааны бий болох, хувь хүний виртуал мэдээллийн нууц алдагдах, инженер техникийн боловсон хүчний дутагдал, гаж төрөлт ихсэх, хорт хавдрын өсөлт, хүн амын шилжих хөдөлгөөн ихсэх зэрэг асуудлууд "улс төржсөн"-өөр шаардлагатай хөрөнгө санхүү босгох, нийгмийн ухамсар төлөвших, зохицуулалтын эрх зүйн болон ёс зүйн орчин бүрэлдэхэд чухал хөшүүрэг болдог юм.

**Хэтийдсэн улс төржилт бий болдог шалтгаан**

а/ Улс төрчид болон Иргэний хөдөлгөөний хүрээнд:

- Ээлжит сонгуулийн үеэр сонгогчдод бодлогогүй амлалт өгөх
- Янз бүрийн асуудал хөндөж, улс төрийн дуулиан тарих замаар ашиг хонжоо олох /Гэхдээ заримдаа хөндсөн сэдэв нийгмийн эрх ашигтай давхцах явдал гардаг ч энэ нь ховор/
- Нийгмийн захиалгаар биш хувийн эсвэл бусдын сэдэлтэй улс төржих хандлага
- Бодлогод биш өөрийн реклам сурталчилгаанд илүүтэй анхаарах
- Өөрийн нэр хүндэд сэвтэй үйл явдлаас олон түмний анхаарлыг холдуулах зорилгоор өөрийн олонд танигдсан байдлаа ашиглан үр ашиггүй сэдвээр яриа хэлэлцүүлэг өрнүүлэх
- Үнэн бодит байдлаас хол асуудлаар олон нийтийн толгойг эргүүлэх
- Намаар талцах, намчирхах
- Бусдын үзэл бодлыг үл тоох, үл хүндэтгэх
- Хөгжлийн төлөөхи бодлогыг улс төрийн зорилгоор гуйвуулах, шуугиан тарих
- Хууль, хяналтын байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс нөлөөлөх

б/ Хэвлэл мэдээллийн хэрэгслийн хүрээнд:

- Чөлөөт учраас хэн, юу хүссэнээ бичиж нийтэлж, үгээ чөлөөтэй хэлж байна гэсэн халхавч хийх
- Нийгмийн анхаарлыг тодорхой асуудалд татах чадвараа зарим тохиолдолд аар саархан ярианы сэдэв болгох
- Улс төрчдийн хуурмаг явууллагаар улс төржилтийг хөөрөгдөх
- Захиалгат, төлбөрт нийтлэл, нэвтрүүлэг нийтлэх, нэвтрүүлэх

в/Олон нийтийн дунд

- Намаар талцах, намчирхах
- Буруу ташаа мэдээлэлд үндэслэн үр дүнгүй улс төржиж, итгэл үнэмшлээрээ бус улс төрийн хүчин, хөдөлгөөнүүдийн гар, хөл болох
- Намуудад үл итгэх
- Ирээдүйдээ итгэх итгэлээ алдах
- Бүтээн босгох бус бэлэнчлэх
- Нийгмийн баялагийн шударга бус хувиарлалтын сөрөг үр дагавар

**Хэтийдсэн улс төржилтын сөрөг үр дагавар:**

- Үндэслэл муутай, бодит бус мэдээлэл нийгэмд тархана.
- Хийсвэр оновчгүй шийдвэр дүгнэлтүүд хийгдэнэ.
- Нийгмийн хүч нөөцийг дэмий зүйлд зарцуулахад хүргэнэ. /Хөгжлийг сааруулна/
- Аливаа сонголт буруу хийгдэнэ.
- Зарим тохиолдолд Үндэсний аюулгүй байдал, оршин тогтнолд аюул учруулахуйц байдалд ч хүргэж болно.

**Хэтийдсэн улс төржилтийн дүнд хийгддэг үйлдлүүд:**

Сайн засаглалын зарчмууд /ил тод байдал, хариуцлага, иргэдийн оролцоо/ үл хэрэгжих

- Жагсаал, цуглаан хийх / Ард түмэн бол агуу, бас хүчирхэг. Гэхдээ энэхүү хүч тооны олон цөөнөөр бус, эв нэгдлээр л илэрхийлэгддэг ажээ. Хэчнээн олон мянган хүн, хэчнээн зөв юмны төлөө жагссан ч, тэр нь хүчирхийлэл болбол уг тэмцлийн агуулга алдарч, нийгэмд хаос болж муу нэртэй үлддэг тухай судлаачдын бичсэн нь бий. Жишээ нь, долдугаар сарын 1-ний үйл явдал бол сонгуулийн луйврыг эсэргүүцсэн шударга тэмцэл байсан гэж олон хүн хэлдэг. Эцэстээ хүчэрхийлэл болсон учраас энэ үйл явдлыг өнөөдөр “хар өдөр”, “долдугаар сарын 1-ний үймээн” гэх зэргээр дандаа сөргөөр, сайны бус, саарын жишээнд оруулж ярьж бичдэг.
- Албан тушаал, боловсон хүчний томилгоо /Улс төрийн үзэл бодол, намын харьяалал, авлига, хээл хахууль, тухайн хүний чадвар чадавхи, ах дүү, төрөл садангийн холбоо/
- Улс төрийн хямралаас үүдсэн салбарын бодлого, үйл ажиллагааны уналт
- Зохиомол үнийн хөөрөгдөл
- Хувийн компаниудын шударга бус үйл ажиллагаа /Жишээ нь, дэлхийн зах зээл дээр буудайны үнэ бууж байхад манайд талхны үнэ өсч байх/
- Засгийн газрын бодлогыг гуйвуулах
- Хуулийг өөрийн бизнесийн эрх ашигт нийцүүлэн өөрчлөх, улмаар лобби аргаар батлуулах /Уршиг нь үнийн хөөрөгдлийг бий болгож, өрсөлдөөнийг бууруулдаг/
- Бодлогын буруу шийдвэр
- Бодлого, шийдвэрийн ил тод бус байдал
- Мэдээллийн ил тод бус байдал
- Хувийн ашиг сонирлын үүднээс асуудалд хандах, хамгаалах
- Ашигт малтмал юмуу ашигтай бизнес тойрсон шударга бус үйлдэл түүнийг тойрсон хардалт /Жишээ хавсаргав/

#### Хэтийдсэн улс төржилтийг өдөөдөг субъектүүд:

- Улс төрчид
- Хэвлэл мэдээллийн хэрэгсэл
- Иргэний хөдөлгөөн
- Үйлдвэрчний эвлэл /зарим асуудлаар/

Эх сурвалж: [http://www.doldon.com/xel/index.php?document\\_srl](http://www.doldon.com/xel/index.php?document_srl)

\*\*\*

Хавсралт:

**Уул уурхайг улстөржүүлэхээ больж, мэргэжлийн хүмүүс орёё,**  
2008 оны 4-р сарын 8

Эх сурвалж: [www.mongolnews.mn](http://www.mongolnews.mn)

Уул уурхай нэгэнт тэргүүлэх салбар болсон учраас энэ асуудлаар ярихгүй улс төрийн нам хүчин, улстөрч ч гэж байхгүй болсон. Мөн сүүлийн үед иргэний болон төрийн бус байгууллагууд ч энэ талаар янз янзын байр суурь илэрхийлж буй. Халуун сэдэв болсон ашигт малтмалын асуудлаар “Өнөөдөр” сонин, “MN-25” дугаар суваг телевизийнхэн мэргэжлийн хүмүүсийг урьж ярилцлаа. Ярилцлагад Үйлдвэр, худалдааны дэд сайд Я.Содбаатар, АМГТХЭГ-ын Кадастрын албаны дарга Т.Бат-Оргил, Монголын уул уурхайн ассоциацийн тэргүүн М.Ганболд, Дэлхийн банкны төслийн зөвлөх Энрике Ортега нар оролцлоо.

**-Уул уурхайн салбарыг хэт улстөржүүлэх нь мэргэжлийн байгууллагад тухайлбал, танай Кадастрын албанд хэрхэн сөргөөр нөлөөлдөг вэ?**

**Т.Бат-Оргил:** Аливаа шийдвэр судалгаан дээр үндэслэх ёстой. Гэтэл одоо ярьж байгаа хүмүүсийг ажиглахад судалгаа байтугай наад захын бидэнд байгаа мэдээллийг ч авч хэрэглэхгүй байна. Баримт аваад үзэхэд, нэг хувь хүрэхгүй газар нутагт ашиглалт явуулж байхад, нийт нутаг дэвсгэрийг ухаад онгичоод, зарчихлаа гээд яриад байна.

Манайх судалгааны зориулалттай Статистик, эдийн засгийн тасаг гэж байгуулж буй. Ер нь хэтэрхий улстөржүүлээд бодит тооцоо судалгаан дээр үндэслээгүй шийдвэрүүд гаргах юм бол энэ салбар унаж, Монголын эдийн засагт асар их хор хохирол учирна. Энэ талаар хаа хаанаа их л хариуцлагатай баймаар. Бүх хүн эх орондоо хайртай шүү дээ. Зөвхөн хөдөлгөөнийхөн хайртай, би болохоор харь орны хорлон сүйтгэгч ирчихээд байгаа юм биш. Уул уурхайг улстөржүүлэхээ больж, мэргэжлийн хүмүүс орж эхлэх хэрэгтэй байна.

**М.Ганболд:** - Уул уурхайн салбар олон улсын практикт яаж хөгжиж ирсэн түүхийг өнөөдрийн нөхцөл байдалтай нь уялдуулж авч үзэхийг хэзээ ч үгүйсгэхгүй. Улс төрийг л аваад хаячихвал энэ салбар эрүүл болох гээд байгаа. Уул уурхайн салбарыг ингэж хэлээд шүүмжилчихвал надад хэдэн санал ирчих болов уу. Ирэх сонгуульд энэ талаар яривал сонгогдчихно гэх явуургүй бодлоор уул уурхайн салбараар тоглоом хийгээд байж таарахгүй.

**Я.Содбаатар:** - Дотоод дахь ойлголцол маш чухал. Нэг үеэ бодоход ашигт малтмалын үнэ ханш өсөөд, хөрөнгө оруулагчид сонирхож, гадаад орчин таатай болж байна. Эхний ээлжинд улс төрийн намууд, нийгмийн харилцаанд орж байгаа субъектуудын хүрээнд дотоодын ойлголцлыг нэг цэгт хүргэмээр. Тэгэхгүйгээр томоохон орд газруудын шийдэл аль нэг тийш туйлширвал эдийн засагт маш их хохирол учирч болзошгүй.

**М.Ганболд:** - Мэргэжлийн хүмүүс нь салбараа ярихгүй бол, уул уурхайг эмч, багш, яриад эхлэхээр юу болох вэ. Хэрвээ намайг хүнд мэс засал хий гэвэл алж л таарна биз дээ, өөр яах юм. Бүгдийг хольж хутгаж ойлгож болохгүй. Юугаар тоглож болох, болохгүйгээ бас мэдэж баймаар. Аливаа юманд хэмжээ хязгаар гэж бий. Улс төр бол хэмжээ хязгааргүй болчихлоо л доо.

**Энрике Ортега:** - Бүх дэлхийн практикийг мэднэ гэж өөрийгөө хэлэхгүй. Гэхдээ 20 орчим орны кадастрын газарт удаан хугацаагаар ажилласан. Мөн тооны орны хууль тогтоомжийг нь бас мэднэ. Миний мэддэг 50-иад улсын хууль тогтоомжид стратегийн орд гэсэн ойлголт байдаггүй. Ази, Африк, АНУ-ын туршлагыг судалсан л даа. Зарим оронд стратегийн орд гэсэн ойлголт байдаг. Сүүлийн 10 гаруй жилд 30 гаруй орон Ашигт малтмалын тухай хуулиа шинэчилсэн. Тэд стратегийн орд биш, ашигт малтмалын минералиудыг хуулиасаа авч хаясан юм.

**Я.Содбаатар:** - Манай ашигт малтмалын салбарын нэр хүнд дотоод, гадаадад яагаад доошлоод байна вэ гэдэг дээр бодох асуудал нь хууль эрх зүйн орчны тогтворгүй байдал. Эрх зүйн орчны тодорхойгүй байдлыг цаг алдалгүй засахын төлөө манай яам ажиллаж байгаа. Аль болох олон нийтэд нээлттэй болгох, төр, засгаас хувь хүн болоод ямар нэгэн түшмэлийн оролцоогүй шийдвэр гаргах чиглэлд анхаарч буй. Тиймээс Дэлхийн банктэй хамтраад кадастрын төсөл хэрэгжүүлж байгаа. Энэ бол тэнд буй хэн нэгэн түшмэл, аль нэгэн даргаас хамаардаг системийг аль болох багасгах бодлого юм. Эрх зүйн орчныг тогтвортой байлгах асуудал нэн чухал байгаа. Мөн сонгууль болох гэж буйтай холбоотойгоор уралдаад мөнгө амлаад эхэллээ. Амлаад буй тэр их мөнгөнийх нь эх үүсвэр хаана байна вэ гэхээр ашигт малтмалын салбараас хийнэ гээд байгаа. Хэрвээ үнэхээр үүнийг хэрэгжүүлэх гэж байгаа юм бол энэ Парламентаар хуулиа гаргаад, гэрээнүүдээ цаг алдалгүй байгуулах хэрэгтэй.



### 3. Нутгийн өөрөө удирдах байгууллагыг хэрхэн сонгодог талаар

Энэхүү мэдээллийг зарим улс орны Үндсэн хууль болон орон нутгийн сонгуулийн тухай хуулиудыг судалж үзсэний үндсэн дээр бэлтгэв. Хууль эрх зүйн хувьд улс бүр өөр өөрийн ялгагдах онцлогтой байна. Япон, Бүгд Найрамдах Унгар Улс, Бүгд Найрамдах Бангладеш Ард Улс, Польш, Бүгд Найрамдах Болгар Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Казахстан Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс зэрэг орнуудад орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нь бие даан нэрээ дэвшүүлэх, тухайн улс төрийн намууд нэрийг нь дэвшүүлэх зарчмаар явагдаж байна.

Зарим нэг онцлогийг дурьдвал:

- Япон улс нь тухайн улс төрийн намд нэр дэвшүүлэх хүний тоон хязгаарыг тогтоож өгдөг.
- БНУУ-д тухайн орон нутагт байнгын оршин суугчийн нэрийг дэвшүүлэх, түүнчлэн Төрийн бус байгууллага нэр дэвшүүлэх эрхтэй.
- БНСУ-д бие даан нэр дэвшигч нь хичнээн хүний гарын үсэг авах болон мөнгөний барьцааг хуульд тодорхой заадаг.
- БНКазахстан улсад тухайн тойргийн сонгуульд өргөдөл гаргаж нэр дэвших, хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах зэргийг орон нутгийн сонгуулийн тухай хуулинд зааж өгчээ.

Дээр дурьдсан орон тус бүрийн Үндсэн хуульд хэрхэн тогтоосныг орон тус бүрээр авч үзвэл:

1. Япон улсын Үндсэн хуулийн Наймдугаар бүлэг /Орон нутгийн өөрийн удирдлага/-ийн 92 дугаар зүйлд “Орон нутгийн нийтийн эрх зүйн этгээдийн зохион байгуулалт, үйл ажиллагаатай холбогдох журмыг орон нутгийн хараат бус байдлын зарчимд нийцүүлэн хуулиар тогтооно”.

93 дугаар зүйлд “Нийтийн эрх зүйн этгээдийн хурлын гишүүдийг нийтийн, шууд сонгуулиар сонгоно” гэжээ.

Япон улсын Сонгуулийн тухай хуулийн 86 дугаар зүйлд “Парламентад 5-аас доошгүй гишүүнтэй улс төрийн нам, хамгийн сүүлийн сонгуулийн саналын 2-оос доошгүй хувийн саналыг авсан улс төрийн нам нэр дэвшигчийг зарлана. Гэхдээ бие даан нэр дэвшигч дэвшиж болно” гэжээ.

2. Бүгд Найрамдах Унгар Улсын Үндсэн хуулийн Есдүгээр бүлэг /Нутгийн удирдлага/-ийн 42 дугаар зүйлд “Нийслэл хот, коммун болон мужуудын сонгогчид нутгийн өөрөө удирдах байгууллагыг сонгох эрхтэй”. Мөн хуулийн 71 дүгээр зүйлд “Парламентын гишүүд нутгийн өөрөө удирдах байгууллагын гишүүд, нийслэл бусад нэгжийн захирагчийг нийт ард түмнээс шууд, нууц, тэгш эрхийн үндсэн сонгоно” гэж заажээ.

БНУУ-ын Сонгуулийн процессийн тухай хуулийн 46 дугаар зүйлд “Орон нутгийн сонгуульд нэр дэвшигчийг санал болгох хуудсаар дэвшүүлэх бөгөөд тухайн тойргийн байнга оршин суудаг сонгогч нь сонгууль болохоос 23 хоногийн өмнө нэрийг нь дэвшүүлнэ” гэжээ. Мөн байгууллагаас орон нутгийн сонгуулд нэр дэвшүүлж болно. Тухайлбал, уг хуулийн 51 дугаар зүйлд Унгар улсын шүүхэд бүртгэлтэй Төрийн бус байгууллага нь нэр дэвшүүлж болохоор заасан байна.

3. Бүгд Найрамдах Бангладеш Ард Улсын Үндсэн хуулийн Гуравдугаар бүлэг /Нутгийн өөрийн удирдлага/-ийн 59 дүгээр зүйлд “Бүгд найрамдах улсын захиргааны нэгж тус бүрт хуулийн дагуу сонгогдсон гишүүдээс бүрдсэн нутгийн өөрөө удирдах байгууллага байна” гэжээ.

4.Польш улсын Үндсэн хуулийн Долоодугаар бүлэг /Орон нутгийн өөрөө удирдах

байгууллага/-ийн 169 дүгээр зүйлд “Орон нутгийн сонгуулийг нийтээрээ, шууд, тэгш эрхтэй, нууцаар санал хурааж явуулна” гэжээ.

5.Бүгд Найрамдах Болгар улсын Үндсэн хуулийн 136 дугаар зүйлд “Иргэд удирдах үйл ажиллагаанд өөрсдийн сонгож байгуулсан нутгийн төлөөллийн байгууллагаараа уламжлан эсхүл бүх нийтийн санал хураалт болон нийт иргэдийн хурлаар дамжуулан оролцож болно” гэжээ.

6.Бүгд Найрамдах Чех Улсын Үндсэн хуулийн Долоодугаар бүлэг /Нутгийн өөрийн удирдлага/-ийн 102 дугаар зүйлд “Нутгийн өөрийн удирдах байгууллагын төлөөлөгчдийг сонгуулийн эрх бүхий иргэд нийтээрээ, тэгш, шууд сонгох эрхийн үндсэн дээр саналаа нууцаар гаргаж сонгоно” гэжээ.

7.БНСУ-ын Үндсэн хуулийн Наймдугаар бүлэг /Орон нутгийн засаг захиргаа/ийн 118 дугаар зүйлийн 2 хэсэгт “Орон нутгийн хурлын бүрэн эрх, орон нутгийн захирагч нарын бүрэн эрх, сонгох болон сонгогдох сонгуулийн үйл ажиллагааг тусгай хуулиар зохицуулна” гэжээ.

БНСУ-ын “Орон нутгийн өөрөө удирдах хууль”/1949/-ийн 26, 32 дугаар зүйлд “Орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийг тэгш, шууд, нууц санал хураалтаар сонгоно. Орон нутгийн сонгуульд нэр дэвшигч нь улс төрийн нам, эвсэл болон бие даан нэр дэвших гэсэн хоёр хэлбэртэй байна. Хот, мужийн захирагчид бие даан нэр дэвшигч нь 1000-2000 хүний, Иргэдийн хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь 100-200 хүний дэмжлэг буюу дэмжигчдийнхээ гарын үсгийг цуглуулсан байх ёстой.

Өөрөө удирдах дүүрэг, хот гүний засаг даргад нэр дэвшигч нь 300-500, Иргэдийн нийтийн хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь 50-100 хүний дэмжлэг буюу дэмжигчдийнхээ гарын үсгийг цуглуулсан байна. Нэр дэвшигчийг орон нутгийн сонгуулийн санал хураалтаас 15 хоногийн өмнө бүртгэж, барьцааны мөнгө авна. Хот, мужийн захирагчид бие даан нэр дэвшигч нь /50 сая won/, Иргэдийн хурлын төлөөлөгчид нэр дэвшигч /3 сая won/, Өөрөө удирдах дүүрэг, хот гүний засаг даргад нэр дэвшигч нь /10 сая won/, Иргэдийн нийтийн хурлын төлөөлөгчид нэр дэвшигч нь /2 сая won/ барьцааны мөнгийг төлж, сонгуульд ялбал суутгалаа төлөөд буцааж авах, ялагдвал тодорхой хувийг буцааж авах нөхцөлтэй байна” гэж заажээ.

8.Бүгд Найрамдах Казахстан Улсын Үндсэн хуулийн Наймдугаар бүлэг /Орон нутгийн засаг захиргаа ба өөрөө удирдах/-ийн 86 дугаар зүйлд “Орон нутгийн төлөөллийн байгууллагыг Маслихат гэх бөгөөд тухайн орон нутагт хүн амыг төлөөлөх болон нийтийн эрх ашгийг хамгаална”, “Маслихат нь бүх нийтийн, тэгш, нууц санал хураалтаар 4 жилийн хугацаатай сонгогдоно” гэжээ.

Тус улсын “Сонгуулийн тухай хууль”-ийн 103 дугаар зүйлд тогтоогдсон журмын дагуу бүртгэгдсэн улсын болон орон нутгийн нэгдлүүд Маслихат нэр дэвшүүлнэ. Мөн иргэд бие даан нэр дэвшиж болно. Маслихатын депутатад иргэн бие даан нэр дэвших бол тойргийн сонгуулийн хороонд нэр дэвших өргөдөл өгнө. Бие даан нэр дэвшигч нэгээс илүү сонгуулийн тойрогт нэр дэвшиж болохгүй. Мөн нэр дэвшигч нь тойргийн сонгуулийн хорооны дансанд мөнгө байрлуулах, уг мөнгийг хэрхэн буцаан авах нөхцөл, нэр дэвшигч түүний эхнэр, нөхрийн хөрөнгө орлогын мэдүүлэг багтана гэж тус тус заажээ.

\*\*\*

#### Эх сурвалж:

- Япон Улсын Үндсэн хууль. Орч П.Амаржаргал, “Адмон” хэвлэл, УБ., 2011
- “Орон нутгийн сонгуульд улс төрийн намууд оролцох нь” Бодлогын судалгаа шинжилгээ. Х боть, 256-287 х, УБ., 2011

- [www.freechoice.jp/electionsystem.pdf](http://www.freechoice.jp/electionsystem.pdf)
- <http://www.legislationline.org/documents/action/popup/id/5326>
- <http://www.online.bg/law/const/const0.htm>
- [http://www.servat.unibe.ch/icl/hu00000\\_.html](http://www.servat.unibe.ch/icl/hu00000_.html)
- <http://www.sejm.gov.pl/prawo/konst/angielski/kon1.htm>
- <http://unpan1.un.org/intradoc/groups/public/documents/APCITY/UNPAN014593.pdf>
- [http://en.wikipedia.org/wiki/Local\\_elections\\_in\\_Poland](http://en.wikipedia.org/wiki/Local_elections_in_Poland)
- [http://en.wikipedia.org/wiki/Elections\\_in\\_Hungary](http://en.wikipedia.org/wiki/Elections_in_Hungary)
- <http://wtd.vlada.cz/scripts/detail.php?id=8073>
- [http://korea.assembly.go.kr/res/low\\_01\\_read.jsp?boardid=1000000035](http://korea.assembly.go.kr/res/low_01_read.jsp?boardid=1000000035)
- [http://www.kazakhstan.orexca.com/kazakhstan\\_constitution.shtml](http://www.kazakhstan.orexca.com/kazakhstan_constitution.shtml)


#### 4. Орон нутгийн болон УИХ-ын сонгуулийг хамт явуулдаг орнуудын талаар

Парламентын болоод орон нутгийн сонгуулийг зэрэг явуулах нь эдийн засгийн үргүй зардлыг хэмнэдэг сайн талтай бөгөөд орчин үед нэлээд орон сонгуулийн энэхүү тогтолцоог сонирхон ярилцаж байна. Өндөр хөгжилтэй орнуудаас АНУ, Австрали, хөгжиж буй орнуудаас Болгар, Филиппин зэрэг улс сонгуулиудаа зэрэг явуулж эхэлжээ. 2020 гэхэд Европын Холбооны орнууд энэ замаар сонгуулиа зохион байгуулна гэж ажиглагчид үзэж байна. Бельги, ялангуяа Герман улс үүнд илүү анхаарлаа хандуулж байна. Энэхүү лавлагаанд Филиппин улсын туршлагыг дэлгэрэнгүй судалж, бусад орнуудын мэдээллийг нэмж тусгав.

Филиппин улсын туршлага: Тус улс нь сонгуулиа зэрэг явуулахдаа бүрэн автомажсан санал хураалтын технологийг хэрэглэж байгаа нь ардчилсан, шударга сонгуулийн загварыг Өмнөд Азид түгээсэн чухал алхам болжээ. Тус улсын Парламент нь 2 танхимтай бөгөөд Сенат нь 26, Конгресс нь 286 гишүүнтэй. Филиппиний Үндсэн хуулийн 18-р бүлгийн 1-р хэсэгт “Орон нутгийн сонгууль нь Конгрессийн гишүүдийн сонгуультай нэг зэрэг явагдах бөгөөд орон нутгийн сонгуульд хотын бүх гишүүд болон нийслэл Манила орчмын хотуудын захирагч нарын сонгууль багтана” гэж заажээ. Мөн хуулийн 8-р хэсэгт “Орон нутгийн сонгогддог албан тушаалтнуудын бүрэн эрхийн хугацаа 3 жил бөгөөд 3 хүртэл удаагаар улиран сонгогдож болно” гэжээ.

Филиппин улс нь сонгууль явуулах арга технологиороо хөгжиж буй орнуудын хувьд туршлага өндөртэй орнуудын тоонд зүй ёсоор ордог. Сонгуулийн хороо /COMELEC/ нь санал хураалтын автоматжуулалт, санал хураах байрны зохион байгуулалтад анхаарч, гадаадад байгаа өөрийн улсын иргэдийг тус байгууллагын вэб сайтаар онлайн хэлбэрээр санал авах зэргээр сонгуулийг хүртээмжтэй, шударга, чөлөөтэй явуулж санал хураалтын дүнг түргэн шуурхай гаргадаг байна.

Сонгуулийн хороо нь Дарга, хоёр Гүйцэтгэх захирал, 16 орон нутгийн салбарын захирал, 79 зөвлөх менежер, 1609 ажилтантай. 1992 оноос эхлэн тус байгууллага нь санал хураах үйл явцыг автоматжуулж эхэлсэн бөгөөд Optical Mark Reader (OMR) технологийг 1996 оны сонгуульд анх удаа амжилттай туршжээ. 1996 оноос хойш гар аргаар болон автомат хосолсон замаар санал хурааж байсан бол 2010 оноос эхлэн бүрэн автомажсан технологи ашиглаж байна. Санал хураалт, тооллогын автомат машиныг доори зургаас харж болно.



2010 оны 5 дугаар сарын 10-нд явагдсан Үндэсний болон орон нутгийн сонгуулийн санал өгөх, саналыг тоолох, дүнг гаргаж мэдэгдэх талаархи Ажиглагч нарын ерөнхий удирдамжийг 8786 тоот тогтоолоор тус оны 03 сарын 04-нд гаргажээ. Тэрхүү тогтоолын 5-р зүйлд “Сонгуулийн ажиглагч нь өглөөний 6 цагт санал хураах байран дахь PCOS хайрцаг буюу саналын хуудасны хайрцаг байгаа эсэхийг шалгаж, мөн саналын хуудасны хайрцагны лац бүрэн бүтэн, хайрцаг хоосон байгаа эсэхийг шалгана. Мөн PCOS машин, хэвлэх цаас, модем зэргийг байх ёстой тоо ширхэгээрээ байгаа эсэхийг шалгана.

Машины нууц дугаарыг сэргээж, ажиллахад бэлэн болгон “Үндсэн цэсний Санал хураалтыг нээх” гэсэн цэсийг идэвхижүүлж, нууц дугаарыг оруулснаар санал авахад бэлэн болно. Санал хураах байр өглөөний 7 цагт нээж оройн 6 цаг хүртэл санал авна. Сонгогч санал хураах байрны үүдэнд хадсан сонгогчдын жагсаалтаас өөрийн нэрийг харж, санал өгөх хэсэг, дарааллын дугаараа авна” зэргээр заажээ.

Тус улсад сургуулийн бүх ангид санал хураах хэсгийн хороог ажиллуулж, модем бүхий машиныг мөн байрлуулсан байдаг. Нэг хэсэгт ойролцоогоор 200 сонгогчийн саналыг авна. Иймээс санал хураалт шуурхай болдог байна. Хэсгийн хорооны ажиглагчид дугаараа өгч, нэр хаяг мэдээллээ шалгуулж сонгуулийн хэсгийн ажилтан нь EDCVL системд мэдээлэл байгаа эсэхийг зураг, гарын үсэг, баримт бичгийг үзсэнээр баталгаажуулсаны дараа нэрийг нь чангаар дуудна. Хумсанд өмнө нь санал өгсөн тэмдэглэгээ байгаа эсэхийг нягталсаны дараа хэрхэн саналаа тэмдэглэхийг зааж өгнө. Хэсгийн хорооны дарга биечлэн саналын хуудсыг өгнө.

Сонгогч саналын хуудасны нууц дэвтэр, тэмдэглэх үзэг ашиглан зааврын дагуу өөрийн сонгох нэр дэвшигч ба намын нэрийг бүтэн тэмдэглэж саналын хуудсыг PCOS машинд оруулж уншуулахад дэлгэцэн дээр “ТАНЫ СОНГОЛТ БҮРТГЭГДЛЭЭ” гэсэн үг гарч ирнэ. Саналын нууц дэвтэр үзгийг даргад буцааж өгч, хумсан дээрээ тэмдэглэгээ хийлгэснээр санал өгөх процесс дуусна. Санал авч дууссаны дараа машины “Санал хураахыг дуусгах”

гэсэн цэсийг сонгож ДҮНГ ГАРГАХ гэсэн цэсийг идэвхижүүлж санал хураалтын дүнг нэр дэвшигчид, намын нэрсийг сонгогдох албан тушаалын нэрээр нь ангилж 8 хувь хэвлэж гаргаад, хэсгийн хорооны дарга, гишүүд гарын үсэг зурна. Дараа нь машины “Дүнг дамжуулах” цэсийг сонгож төв сонгуулийн хороо руу илгээнэ. Ийнхүү Филиппин улсад санал хураалт бүрэн автоматжсан аргаар явагдаж байгаа нь сонгуулийн зөрчил булхай гарах асуудлыг зогсоож чадсан байна.

Эх сурвалж: [http://www.comelec.gov.ph/statistics/2010natl\\_local/toc.html](http://www.comelec.gov.ph/statistics/2010natl_local/toc.html)

### Парламент, орон нутгийн сонгуулийг зэрэг явуулдаг зарим орны мэдээлэл

| Улс орон | Сонгуулиудаа зэрэг явуулдаг талаарх мэдээлэл   |
|----------|--|
| Болгар   | 7.2 сая хүн амтай Болгар улсын хувьд хамгийн сүүлд 2011 оны 10 дугаар сарын 23-нд Ерөнхийлөгчийн болон орон нутгийн сонгуулийг зэрэг явуулсан байна. 2011 оны 2-р сард сонгуулийн хуульдаа өөрчлөлт оруулсан. Сонгуулийн хороо нь 5 жилийн хугацаатайгаар томилогдож 21 гишүүдээс бүрдсэн. Сонгуулийн хэсгийн хороо нь 1000 хүртэл сонгогчдыг авдаг. Эрүүгийн хуулиндаа 2011 оны 4-р сард өөрчлөлт оруулж, хэвлэл мэдээллийн байгууллагын сонгуулийн үед баримтлах зарчим, хүлээх хариуцлагыг нэмэгдүүлсэн байна.<br>Эх сурвалж: <a href="http://www.osce.org/odihr/elections/83959">http://www.osce.org/odihr/elections/83959</a>   |
| Индонез  | 2009 онд тус улс нь үндэсний, муж, дүүргийн сонгуулийг амжилттайгаар нэг зэрэг явуулсан нь Зүүн Өмнөд Азид ардчиллыг хөгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсан юм. 2008 оноос эхлэн эдгээр сонгуулийг зэрэг явуулах талаар парламентын гишүүд эсрэг байр суурьтай байсан ч сонгуулийг зэрэг явуулж чадсан байна. 2008 онд Сонгуулийн тухай хуулиндаа хагас нээлттэй пропорциональ систем, босгыг 2,5 гэж оруулсан зэрэг нь ардчилсан алхам болсон байна.<br>Эх сурвалж: <a href="http://www.google.mn/#hl=mn&amp;source=hp&amp;q=Indonesia+simultaneous+election+law&amp;btnG=Google+%D0%A5%D0%B0%D0%B9%D0%BB%D1%82&amp;bav=cf.osb&amp;fp=351315cd2d2e33d5&amp;biw=1024&amp;bih=636">http://www.google.mn/#hl=mn&amp;source=hp&amp;q=Indonesia+simultaneous+election+law&amp;btnG=Google+%D0%A5%D0%B0%D0%B9%D0%BB%D1%82&amp;bav=cf.osb&amp;fp=351315cd2d2e33d5&amp;biw=1024&amp;bih=636</a>   |
| Тайвань  | Тус улс нь 2012 оны Ерөнхийлөгчийн болон парламентын сонгуулийг зэрэг явуулах болсон. Энэ нь улс төрийн зорилгогүй бөгөөд нийгмийн зардлыг багасгах, улс төрийн шинэчлэлтийг хэрэгжүүлэх, мөн 500 сая тайвань долларыг хэмнэх бололцоотой гэж Сонгуулийн төв хорооны дарга Чанг мэдэгдсэн байна.<br>Эх сурвалж: <a href="http://www.taipeitimes.com/News/front/archives/2011/04/20/2003501206">http://www.taipeitimes.com/News/front/archives/2011/04/20/2003501206</a>  |
| АНУ      | Холбооны болон муж улсын сонгуулиудыг 1975 оноос хойш зэрэг явуулдаг болсон нь эдийн засгийн асар их хэмнэлтийг авчирсан. Муж улсууд нэг л удаа сонгуулийг явуулдаг.<br>Эх сурвалж: The Truth of the Matter, By Gough Whitlam<br><a href="http://books.google.mn/books?id=bQTtYL3KKgcC&amp;pg=PR26&amp;lpg=PR26&amp;dq=simultaneous+elections+in+USA&amp;source=bl&amp;ots=MrBroGpywT&amp;sig=EITkpvsWifFOQIzeMhdgqAuzyI&amp;hl=mn&amp;ei=-8etTvWSAYqqiALQ5PivCw&amp;sa=X&amp;oi=book_result&amp;ct=result&amp;resnum=3&amp;ved=0CCYQ6AEwAg#v=onepage&amp;q=simultaneous%20elections%20in%20USA&amp;f=false">http://books.google.mn/books?id=bQTtYL3KKgcC&amp;pg=PR26&amp;lpg=PR26&amp;dq=simultaneous+elections+in+USA&amp;source=bl&amp;ots=MrBroGpywT&amp;sig=EITkpvsWifFOQIzeMhdgqAuzyI&amp;hl=mn&amp;ei=-8etTvWSAYqqiALQ5PivCw&amp;sa=X&amp;oi=book_result&amp;ct=result&amp;resnum=3&amp;ved=0CCYQ6AEwAg#v=onepage&amp;q=simultaneous%20elections%20in%20USA&amp;f=false</a> |
| Австрали | Сонгуулиудыг нэг өдөр явуулах Америкийн загварыг Австрали улс дагаж Сенат болон Төлөөлөгчдийн хоёр танхимын сонгуулийг зэрэг явуулдаг болжээ. Бүх нийтийн санал асуулгаар хэд хэдэн удаа энэ асуудлыг эсэргүүцэж байсан байна.   |

